

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН

ГҮЙЦЭТГЭГЧ

"ВЕСТ ВАЙБРАНТ СКАЙ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Я.АЛИБЕК

**БУГАТ СУМЫН СУРГУУЛИЙН ДОТУУР
БАЙРНЫ ЗАСВАРЫН АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар БӨАОНӨГ/202206130

Өлгий сум

Нэг талаас Баян-Өлгий аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас РД: 6047912, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7-р хороо, "Вест Вайбрант Скай" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 08 дүгээр сарын 24-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Гэрээний талууд гэрээгээр хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэхэд авлига, ашиг сонирхлоос ангид байх зарчмыг баримтлана.
3. Захиалагч нь Бугат сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг (цаашид "ажил" гэх) 39 494 000 /гучин есөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга/ (цаашид "гэрээний үнэ" гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Гэрээний нийт дүн нь 39 494 000 /гучин есөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга/ (цаашид "гэрээний үнэ" гэх) төгрөг байна. Захиалагч нь санхүүжилтийг Баян-Өлгий аймагт 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих засварын хөрөнгөөс гүйцэтгэлээр олгоно. / Санхүүжилтийг Засгийн газрын 2022 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу бүрдүүлсэн баримт материалыг үндэслэн олгоно.

Үүнд: Урьдчилгаа 30 хувь буюу 11 840 000 /арван нэгэн сая найман зуун дөчин мянга/ төгрөгийг гэрээ байгуулснаар олгоно, үлдэгдэл 27 654 000 /хорин долоон сая зургаан зуун тавин дөрвөн мянга/ төгрөгийг гүйцэтгэлээр олгоно.

Нийт / 39 494 000 төгрөгийн / төсөвт өртөгт:

Нийт ажлын дүн- 34 389 714 төгрөг

НӨАТ /10%/- 3 438 971 төгрөг

Нормчлолын сан /0,18%/- 61 902 төгрөг

Техник хяналтын зардал /2%/- 697 136 төгрөг

Зураг төсөл зохиогчийн зардал – 906 277 төгрөг байна.

5. Гүйцэтгэгч нь "ажлыг" 2022 оны 09 дугаар сарын 10-ны өдөр эхэлж, схем зураг, төсөвт заагдсан нийт ажлыг гүйцэтгэж 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл дуусгана.
6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх).
Үүнд:
Бусад шаардлагатай баримт бичиг;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт;
Зураг;
Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь²;
Санхүүжилтийн хуваарь;
Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Аймгийн ЗДТГ-ын дарга

Б.Мухамед

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга

Х.Анар

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга

Т.Фестиваль

Аймгийн ОНӨГ-ын дарга

Т.Назым

Барилга захиалагчийн албаны дарга

О.Ш.Жанимхан

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Вест Вайбрант Скай" ХХК-ийн захирал

Я.Алибек

Харилцах банк: Капитрон банк
Дансны дугаар: 3005025105

Утасны дугаар: 99420701

Утас: 99427282, 99420642

Гэрээг хянасан: ХЗЗХ-ийн ахлах мэргэжилтэн:

Ө.Тиянах

² Нэгж үнийн гэрээнд "үе шатны ажлын хуваарь" гэснийг "ажлын тоо хэмжээ" гэж солино.